



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,
ШИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/158

Улаанбаатар хот

Агуулга тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн сургалтын нэмэлт агуулгыг нэгдүгээр, сургалтын агуулгын өөрчлөлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. 2017-2018 оны хичээлийн жилээс эхлэн "Гамшгаас хамгаалах мэдлэг олгох хичээл", "Хувь хүний санхүүгийн мэдлэг", "Эдийн засгийн онол", "Хувь хүний санхүү, бизнес, аж ахуй эрхлэлт" сургалтын хөтөлбөрийг тогтоосон цагийн дагуу сургалтын төлөвлөгөөнд тусгаж, нийт суралцагчдыг хамруулан үр дүнтэй зохион байгуулж, ажиллахыг политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн захирал нарт даалгасугай.

3. "Гамшгаас хамгаалах мэдлэг олгох хичээл"-ийг заах мэргэжлийн багшаар хангах асуудлыг батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэхийг төрийн өмчийн политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн захирал нарт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтийг удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/-т үүрэг болгосугай.

САЙД



Н.НОМТОЙБАЯР

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
 2017 оны 0.9 дугаар сарын 01 ний өдрийн
 А/158 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ, МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ-ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
 ТӨВИЙН СУРГАЛТЫН АГУУЛГАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

№	Хичээлийн нэр	Хүрэх үр дүн	Мэргэжлийн боловсрол		Техникийн боловсрол	
			1 жил /цаг	2.5 жил /цаг	1.5 жил /цаг	3 жил /цаг
1	Гамшгаас хамгаалах мэдлэг олгох	Эрсдэл гамшгийн үед аюулгүй байдлаа хангах анхан шатны тусламж үзүүлэх чадвар эзэмшүүлэх	36	54		36
2	Хувь хүний санхүүгийн мэдлэг	Иргэдийн хувийн санхүүгийн талаархи мэдлэг буюу хяналттай төсөвлөлт хийх, ирээдүйн хэрэгцээнд зориулж нөөц, хуримтлал үүсгэх, ирээдүйн тухай тунгаах чадварыг эзэмшүүлэх				18